

Санхүүгийн аудитын газар

**Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны жилийн
эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудит**

Аудитын код: САГ-2017/205/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.gov.mn

Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа

Утас: 261663, 99117973 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 262451, 93014814 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Батсайхан

Утас: 261628, 99058761 Цахим хаяг: batsaikhanj@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
2.9.1	Бараа материал	9
2.9.2	Орлогын данс	9
2.9.3	Биет бус хөрөнгө	10
2.9.4	Орлого	10
2.9.5	Үндсэн хөрөнгө	10
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.12	Шилэн дансны мэдээлэл	12
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	14
3.1	Бараа материал	15
3.2	Орлого	16
3.3	Биет бус хөрөнгө	17
3.4	Орлого	18
3.5	Орлого	19
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	20
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	23
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан	29
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	30

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3 Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/256
танай _____-ны № _____-Т

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ПРОФЕССОР,
ТЭРГҮҮН КОМИССАР С.БААТАРЖАВ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хууль сахиулахын их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын дүн, дүгнэлтийг тус их сургуулийн захирал, профессор, тэргүүн комиссар С.Баатаржав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017-01-25 - наас 2017-02-15 – ны хооронд хийж, аудитын тайланг 2017-02-20 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Ж.Батсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017-01-24 - нд төрийн аудитын байгууллагад 2017-01-24-ны өдрийн 01/217 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хууль сахиулахын их сургууль алсын хараагаа “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль сахиулах ажлын шинжлэх ухаан, боловсрол, үйлчилгээний нэгдлийг хангахуйц инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх, судалгааны тодорхой чиглэлүүдэд тэргүүлэх байр суурьтай, зөвлөх эрхтэй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны хамт олон болон төлөвших замаар ард түмнийхээ энх амгалан байдлыг сахиулах, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулагч мэдлэг, оюуны төв байхад чиглэгдэнэ” хэмээн тодорхойлжээ.

Тус сургууль Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг үнэнч шударгаар хамгаалахад бэлэн мэргэжлийн болон өндөр боловсрол, мэдлэгтэй, төрийн тусгай албаны шилмэл бүрэлдэхүүнийг бэлтгэх, хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх гэсэн эрхэм зорилгын дор дараах зорилт дэвшүүлсэн байна. Үүнд:

- Боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлах төрийн бодлогод тулгуурлан, боловсрол, эрдэм шинжилгээний ажлын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн хүмүүнлэг, ардчилсан, эрх зүйт нийгмийг цогцлон бүрдүүлэх, төлөвшүүлэхэд, шударга ёсыг тогтоох

бат итгэл үнэмшилтэй, мэргэжлийн өндөр боловсрол, ур чадвартай, ёс суртахууны бүрэн төлөвшилтэй төрийн тусгай алба хаагч бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг хангахад оршино.

Хууль сахиулахын их сургууль Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байгаа бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/01 дүгээр тушаалаар тус сургуулийн бүтцийг дараах байдлаар баталсан байна.



Хууль сахиулахын их сургууль өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлсэн байна. Энэхүү гэрээний биелэлтийн тайланаас үзэхэд тус сургууль тайлант хугацаанд тавьсан зорилго, зорилт, албан үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Хууль сахиулахын их сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу тус тургуулийн дотоод хяналт, дотоод аудитын үйл ажиллагааг судалж үзэхэд дотоод хяналт хэвийн байна гэж дүгнэв.

Хууль сахиулахын их сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Хууль сахиулахын их сургууль санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Санхүүгийн тооцоолох компаний Acolous санхүүгийн програм хангамжтай /12 хэрэглэгч/” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хууль сахиулахын их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 6 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 8 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 27 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 6 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн байгууллагын хувьд төсөвт зардал гол үзүүлэлт байдагтай холбоотой юм.

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,858.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 237.2 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тус сургууль өмнөх аудитиудаар зөрчилгүй дүгнэлт авч байсан, санхүү, бүртгэлийн ажилтнууд харьцангуй тогтвортой байгаатай холбоотой юм.

2.8 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Хэрэгжүүлсэн нийт горим сорилоос 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон 1 асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой асуудал гараагүй болно.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	5	41.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		5	41.7	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Бараа материал

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардалд 52.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан бөгөөд энэ зардал 27 нэрийн 4,928.4 мянган төгрөгийн үнэ бүхий дахин ашиглах боломжтой аж ахуйн болон хангамжийн материалыг зарлага болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 дугаар заалт "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна

Гаргасан шийдэл:

Дахин ашиглах боломжтой бараа материалыг бүртгэл, тайланд тусгах зөвлөмж өгөх.

2.9.2 Орлогын данс

Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн төв байрны 942 ам.метр талбайг цайны газар ажиллуулах зориулалтаар ДОРҮ ХХК-д, 33 ам.метр талбайг бичиг хэргийн дэлгүүр ажиллуулах зориулалтаар Хууль сахиулахын их сургуулийн дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлд, АТМ ажиллуулах зориулалтаар Хаан банкинд төрийн өмчийн байрыг ашиглуулах гэрээ тус тус байгуулжээ.

Тус сургууль 2016 онд төрийн өмчийн байр түрээслүүлэх үйл ажиллагаанаас орлого оруулаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 1.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Төрийн өмчийн хорооноос баталсан холбогдох журам зааврыг баримтлана" гэсэн заалтыг зөрчилдөж байна

Гаргасан шийдэл:

Өмнө байгуулсан гэрээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зөвлөмж өгөх

2.9.3 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн ашиглалтын талаарх судалгаанаас үзэхэд 8 нэр төрлийн 18.8 сая төгрөгийн програм хангамж ашиглалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 –д заасан үндсэн хөрөнгийг үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байх, тухайн хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг тухайн байгууллага хүртэх боломжтой байх зарчимтай нийцэхгүй байна.

Гаргасан шийдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийн данс бүртгэлээс хасуулах зөвлөмж өгөх

2.9.4 Орлого

Хууль сахиулахын их сургуулын Замын цагдаагийн тэнхим "Жолооч бэлтгэх сургалт" явуулж, 2016 онд 16.0 сая төгрөг сургалтын төлбөрт төвөрүүлэн зарцуулсан боловч энэхүү орлогыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дүгээр зүйл "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" (.....14.4.1. аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.5 бүх орлого; 14.4.6 бүх зардал;) гэсэн заалттай нийцэхгүй байна.

Гаргасан шийдэл:

Дээрх орлого, зарлагыг бүртгэл, тайланд тусгах зөвлөмж өгөх

2.9.5 Үндсэн хөрөнгө

Хууль сахиулахын их сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, акталж, данснаас хасах барилга, байгууламжийн жагсаалтыг 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 347 дугаар тушаалаар баталсан боловч, тус сургууль энэ шийдвэрийг 2017 оны 1 дүгээр сарын 25 өдөр хүлээн авсан тул нягтлан бодох бүртгэл, тайланд дээрх өөрчлөлт тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дүгээр зүйл "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" (.....14.4.1. аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал;) гэсэн заалттай нийцэхгүй байна.

Гаргасан шийдэл:

Үндсэн хөрөнгийг зохих шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасах зөвлөмж өгөх

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны чиглэлийг хууль, тогтоомжид бүрэн нийцэж байгаа эсэхийг үйл ажиллага тус бүрээр нраийвчлан судалж, дүн шинжилгээ хийх

Аудитын явцад анхаарал татахуйц асуудал гараагүй

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хууль сахиулахын их сургууль өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 10,586.5 сая, хөрөнгийн зардалд 4,881.4 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	15,467.9	15,420.8		-47.1
1.1	Урсгал зардал	10,586.5	10,539.5		-47.1
1.2	Хөрөнгийн зардал	4,881.4	4,881.4		0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0		0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих	10,374.6	10,327.5		-47.1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	211.8	211.8		

Төсөвт зардлын нийт гүйцэтгэл тайлант хугацааны эцэст 47.1 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 12.5 хувь буюу 24.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.7 хувь буюу 10,2 сая, багаж, техник хэрэгслийн зардлыг 18.5 хувь буюу 23.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Харин тавилга эд хогшлын зардал 22.9 сая төгрөгөөр хэтэрсэн нь багаж, тоног төхөөрөмжийн зардлаас цэцэрлэг байгуулахтай холбоотой бүлэг хооронд гүйлгэж зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсвийг хэтрүүлээгүй боловч зөвшөөрөгдсөн хэмжээнд төсвийн дараах томоохон зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

3000 сонсогчийн хичээлийн байр хугацаандаа ашиглалтанд ороогүйгээс байр ашиглалтын зардал 459.0 сая төгрөгөөр, дотуур байранд байрлах сонсогчдын тоо буурсанаас хоол, хүнсний зардал 745.4 сая төгрөгөөр тус тус хэмнэгдснийг УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоол, 2016 оны төсвийн тодотголоор зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна эдгээр хэмнэлтийг хичээлийн 1, 2-р байрны урсгал засварт 100.0 сая төгрөг, алба хаагчдын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварт 200.0 сая төгрөг, тоног төхөөрөмж, тавилга хогшил, зөөлөн эдлэл авахад 71.0 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид 275.2 сая төгрөг, ном, сурах бичиг авахад 100.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмжид 56.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Хууль сахиулахын их сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Хууль сахиулахын их сургууль 2017-01-11-ны өдрийн 01/99 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хууль сахиулахын их сургууль-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хууль сахиулахын их сургууль-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 БАРАА МАТЕРИАЛ

Илрүүлэлт

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардалд 52.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан бөгөөд энэ зардал 27 нэрийн 4,928.4 мянган төгрөгийн үнэ бүхий дахин ашиглах боломжтой аж ахуйн болон хангамжийн материалыг зарлага болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 дугаар заалт "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн аудитын **Толилуулга ба тодруулга** буюу Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Төрийн өмч хөрөнгийн үрэгдэх, үргүй зарцуулагдах

Зөвлөмж

Тайлант хугацаанд зардал болгосон дахин ашиглах боломжтой 27 нэрийн 4,928.4 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг 2017 эхний хагас жилд нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.2 Орлого

Илрүүлэлт

Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн төв байрны 942 ам.метр талбайг цайны газар ажиллуулах зориулалтаар ДОРҮ ХХК-д, 33 ам.метр талбайг бичиг хэргийн дэлгүүр ажиллуулах зориулалтаар Хууль сахиулахын их сургуулийн дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлд, АТМ ажиллуулах зориулалтаар Хаан банкинд төрийн өмчийн байрыг ашиглуулах гэрээ тус тус байгуулжээ.

Тус сургууль 2016 онд төрийн өмчийн байр түрээслүүлэх үйл ажиллагаанаас орлого оруулаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 1.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Төрийн өмчийн хорооноос баталсан холбогдох журам зааврыг баримтлана" гэсэн заалтыг зөрчилдөж байна

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн аудитын **Эрх ба үүрэг** буюу Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Зөвлөмж

Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн төв байрны илүү зай талбайг түрээслүүлэх тухай 3 гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гаргасан бодлого, шийдвэрт нийцүүлэн, шинэчлэн байгуулж, баталгаажуулах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.3 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Илрүүлэлт

